



ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл болон практик шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 2 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-т “Үндэсний баялгийн сан нь хөгжлийн болон хуримтлалын сан байх, сангийн удирдлагын сайн засаглалыг хэвшүүлэх, сангийн хөрөнгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэддээ хүртээхдээ тэгш байдал, шударга ёсны зарчмыг дээдлэх” чиглэл баримтална гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Эдийн засгийн төрөлжилт, инновац, шинэ технологи, хүний хөгжил, ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих чадавхтай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг бий болгон санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийж, хөрөнгийн удирдлагыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, санхүүгийн үр ашигтай төсөл,

хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн дэмжих, хөрөнгийн хуримтлалыг бий болгох тогтолцоог бүрдүүлнэ” гэж заасан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлж, уул уурхайгаас олох үр шимийг Баялгийн сангаар дамжуулан иргэн бүрд тэгш, шударга хүртээх тогтолцоог бүрдүүлнэ” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд “Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг үндэслэн баялгийн сангийн талаарх төрийн зохицуулалт, тус сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, баялгийн сангийн болон удирдлагын талаарх зохицуулалтыг тусгах зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг Засгийн газраас боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”-ээр тусгасан.

Иймд Үндэсний баялгийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор энэхүү хуулийн төслийг боловсруулна.

1.2.Практик шаардлага

Дэлхийд анх Кувейт улс 1953 онд хөрөнгө оруулж, сангийн баялгийг арвижуулах зорилго бүхий үндэсний баялгийн санг газрын тосны орлогын хуримтлалаар үүсгэн байгуулсан бөгөөд үүнээс хойш Норвегийн Хаант Улс /Норвегийн тэтгэврийн сан/, БНХАУ /Хятадын хөрөнгө оруулалтын корпорац/, Арабын Нэгдсэн Эмират Улс /Абу Даби хөрөнгө оруулалтын сан/, Сингапур Улс /Темасек холдинг, Сингапурын хөрөнгө оруулалтын корпорац/, Бүгд Найрамдах Казахстан Улс /Самрук казына/, Бүгд Найрамдах Турк Улс /Туркийн баялгийн сан/, Австрали Улс /Ирээдүй сан/, Шинэ Зеланд Улс /Тэтгэврийн сан/, Чилийн Бүгд Найрамдах Улс /Эдийн засаг, нийгмийг тогтворжуулах сан/, Канад Улс /Альберта өвийн хадгаламжийн итгэлцлийн сан/, БНСУ /Солонгосын хөрөнгө оруулалтын корпорац/ зэрэг улсууд Үндэсний баялгийн сангаа байгуулсан нь эдүгээ амжилттай ажиллаж, үндэсний баялгаа арвижуулах шилдэг тогтолцоог бий болгоод байна.

Монгол Улсын хувьд хуримтлалын санг Ирээдүйн өв сангийн тухай хуулийн хүрээнд байгуулсан. Монгол Улсын Үндсэн хуульд хууль тогтоомжийг нийцүүлэх чиглэлд зааснаар Үндэсний баялгийн сан нь хуримтлалын болон хөгжлийн сангийн төрөлтэй байхаар заасныг үндэслэн хөгжлийн сангийн төрлийг шинээр бий болгох замаар газрын хэвлийн баялгийн үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд оногдох зарчмыг баримталж Үндэсний баялгийн санг олон улсын жишгийн дагуу байгуулах хэрэгцээ, шаардлага байна.

Иймд төрийн өмчийн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд эзэмшигч компаниудын засаглалыг сайжруулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлж, мөн дотогшоо чиглэсэн нэмэлт хөрөнгө оруулалт хийх замаар уул уурхай, түүнийг дагасан дэд бүтэц болон бусад санхүүгийн үр өгөөжтэй томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, нэмүү өртөг шингэсэн дотоодын үйлдвэрлэлийг

хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлж ажил, орлоготой дундаж давхаргыг тэлэх, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгох үндсэн зорилтыг хангах дотооддоо хөрөнгө оруулалт хийх Хөгжлийн санг байгуулна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу анхдагч хуулийн төсөлд хамаарах бөгөөд үндсэн 3 бүлгээс бүрдэхээр төслийг боловсруулна.

Энэ хуулийн зорилго нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг төвлөрүүлж тэгш, шударга хүртээх Үндэсний баялгийн санг байгуулах Хөгжлийн сан болон Ирээдүйн өв санд баримтлах нийтлэг зарчим, сангийн ил тод байдал, тайлагнал, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилго, үйлчлэх хүрээ, Үндэсний баялгийн сангийн үйл ажиллагаанд баримтлах нийтлэг зарчим, Үндэсний баялгийн сан, түүний төрлийн талаар тодорхойлно;

2.Хоёрдугаар бүлэгт Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн удирдлагад тавигдах нийтлэг шаардлагыг тодорхойлно;

3.Гуравдугаар бүлэгт Үндэсний баялгийн сангийн тайлагнал, ил тод байдал, хариуцлага хүлээлгэх үндэслэл, хууль хүчин төгөлдөр болохтой холбоотой асуудлыг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсанаар баялгийн сангийн төрлүүдийг нэгтгэн тодорхойлсон малгай хуультай болох бөгөөд уг хуулиар баялгийн сангийн хөрөнгийн удирдлагад баримтлах нийтлэг зарчим, сангийн ил тод байдлыг хангах харилцааг зохицуулна. Энэ хууль хэрэгжсэний үр дүнд үндэсний баялгаа арвижуулах, үр өгөөжийг нь одоо ба ирээдүй үед санхүүгийн өгөөжтэйгөөр тэгш, шударга хүртээх зэрэг зэрэг үр дагавартай.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хүрээнд байгуулагдах Хөгжлийн сангийн үйл ажиллагаа нь дотоодын эдийн засагт шууд нөлөөтэй тул баялгийн сангийн үйл ажиллагааг мөнгөний болон сангийн бодлоготой нийцүүлэн явуулах орчин бүрдэж, санд орлого төвлөрүүлэх, сангаас зарцуулалт хийх зэрэг нь урьдчилан тодорхойлогдсон байх ба нийтэд ил тод байдлаар хэрэгжих болно. Түүнчлэн Хөгжлийн санг бий болгосноор Монгол Улсын эдийн засгийн бүтэц төрөлжиж, томоохон хэмжээний хөрөнгө оруулалт шаардсан төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр тодорхой болж, ажлын байр нэмэгдэх, эдийн засгийн өсөлт дунд болон урт хугацаанд тогтвортой өсөх боломж бүрдэнэ. Энэ нь хөдөлмөрийн зах зээлд эерэгээр нөлөөлж бодит цалинг өсгөж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлж иргэдийн амьжиргаанд эерэг нөлөөллийг авчирна.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд

шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Хөгжлийн сангийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах зэрэг хуулийн төсөл болон Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.